



БУЛГАН АЙМГИЙН
СТАНДАРТ, ХЭМЖИЛЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 23-ны өдөр

Дугаар А/33.

Булган

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ОРОН ТООНЫ БУС
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ТОМИЛОХ ТУХАЙ

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.1 дэх заалт, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны А/132 дугаар тушаалаар батлагдсан “Стандарт, хэмжил зүйн газрын баталгаажуулалтын зөвлөлийн дүрэм”-ийг үндэслэн ТУШААХ нь:

1.Тохирлын үнэлгээний тайлан, дүгнэлтийг үндэслэн тохирлын гэрчилгээ олгох, хүчингүй болгох чиг үүргийг хэрэгжүүлэх баталгаажуулалтын орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Зөвлөлийн дарга: Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга (Стандарт, хэмжил зүйн газрын баталгаажуулалтын зөвлөлийн дүрэмд зааснаар)

Гишүүд: Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Ахлах мэргэжилтэн
Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн
МХГ-ын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүлэгч

Нарийн бичгийн дарга: Стандарт, хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн

1.Тохирлын үнэлгээг холбогдох хууль, бусад эрх зүйн актын хүрээнд чанартай гүйцэтгэж, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж байхыг бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтэн, “Стандарт, хэмжил зүйн газрын баталгаажуулалтын зөвлөлийн дүрэм”-ийг мөрдөж ажиллахыг Баталгаажуулалтын зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

2.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2019 оны А/95 тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

